

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 3 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

УИХ, ЭЗБХ-ны тогтоолыг хэрэгжүүлэх
ажлын төлөвлөгөө батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2009 оны 22 дугаар тогтоол, Эдийн Засгийн Байнгын Хорооны 2009 оны 17 дугаар тогтоолын заалтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөг тогтоосон хугацаанд хорооны ажлын албаны 2009 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөтэй уялдуулан зохион байгуулж хэрэгжүүлж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд үүрэг болгосугай

2.Төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/, Эрх зүйн хэлтэс /О.Батбилэг/-т тус тус даалгасугай

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

УИХ-ын 2009 оны 22 дугаар тогтоол, Эдийн Засгийн Байнгын Хорооны 2009 оны 17 дугаар тогтоолын
заалтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх ажил	Тогтоолоор өгөгдсөн чиглэл		хугацаа	Хариуцах эзэн	Гүйцэтгэлд хяналт тавих хүн
		22 дугаар тогтоол	17 дугаар тогтоол			
1	“Хадгаламж, зээлийн хоршооны тухай” хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгтэй хамтарч ажиллах	Хадгаламж, зээлийн хоршооны эрх зүйн үндсийг тодорхойлж, түүний үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах		УИХ-ын 2009 оны хаврын ээлжит чуулган	Н.Оюунчимэг	Д.Баярсайхан
2	1.“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуульд болон нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгтэй хамтарч ажиллах 2. Санхүүгийн түрээсийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судлах, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулахад оролцох	Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, түүнээс санхүүгийн зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалт	1.ВСЦ-ийн зохицуулалтын эрх зүйн орчинг тодорхой болгож, ВСЦ-ийн зохицуулалтын асуудлыг шийдвэрлэх үүднээс “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”-д нийцүүлэн ББСБ болгон зохион байгуулах 2.Судалгааны хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	УИХ-ын 2009 оны хаврын ээлжит чуулган	Н.Оюунчимэг	Д.Баярсайхан
3	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төсөл боловсруулах ажилд	Ипотекийн хоёрдогч зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлж, банкнаас		УИХ-ын 2009 оны хаврын ээлжит чуулган	Ажлын хэсэг Д.Дүгэржав	Д.Баярсайхан

	оролцох	олгосон орон сууцны урт хугацааны зээлийн хөрөнгийг эргэлтэнд оруулж банкны мөнгөний урсгалыг сайжруулах				
4	Үл хөдлөх хөрөнгө барьцаалах тухай хуулийн төсөл боловсруулах ажилд оролцох	Үл хөдлөх хөрөнгө, түүнтэй холбоотой эрх үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон барьцаалах, үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ байгуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдсон харилцааг зохицуулах		УИХ-ын 2009 оны хаврын ээлжит чуулган	Ажлын хэсэг Д.Дүгэржав	Д.Баярсайхан
5	1.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг шинэчилсэн найруулга хийсэн хуулийн төслийг УИХ-д хэлэлцүүлэх 2. Шинэчлэн найруулсан “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн төсөл боловсруулж байгаатай холбогдуулан бусад хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Тухайлбал, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажилд хамтран оролцох		1.Үнэт цаас гаргахтай холбоотой хийгдэх үнэлгээний бодит байдлыг хангах, хувьцаа эзэмшигчдийг эрсдэлээс хамгаалах, үнэт цаас гаргагч, зуучлагч мэргэжлийн байгууллага, андеррайтерын хариуцлагыг өндөржүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх 2. Үнэт цаас гаргах талаар хуурамч мэдээлэл өгсөн, хөрөнгө оруулагчдыг санаатай төөрөгдүүлж хохирол учруулсан бол эрүүгийн хариуцлага	1,2.Хаврын чуулганд хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй ч хөрөнгө оруулалтын сангийн хуультай багцаар нь хэлэлцүүлнэ	Ажлын хэсэг Д.Дүгэржав Х.Бум-Эрдэнэ М.Болортуяа	Д.Баярсайхан

	ЗҮнэт цаас шинээр гаргах болон бүртгэлээс хасах ААН-д хөрөнгийн үнэлгээний тайланд чанарын хяналт хийх аргачлал боловсруулах		хүлээлгэх 3. ХК-ны үйл ажиллагаанд хяналт тавих, санхүүгийн тайланг баталгаажуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох			
6	Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төсөл боловсруулах ажилд оролцох	Улсын болон бүс нутгийн ач холбогдолтой томоохон төслийг санхүүжүүлэх үнэт цаасны эргэлтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхүйц хамтын хөрөнгө оруулалтын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах		УИХ-ын 2009 оны хаврын ээлжит чуулган	Д.Дүгэржав Х.Бум-Эрдэнэ	Д.Баярсайхан
7	Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төсөлд хорооны саналын тусгах	Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлж, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг бэхжүүлэн, банкны байгууллагад тавигдах хяналтын тогтолцоог боловсронгуй болгох		УИХ-ын 2009 оны хаврын ээлжит чуулган	С.Ганболд	Б.Шаравсамбуу

8	Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажилд оролцох	Эдийн засгийн харьяат хоорондын болон харьяат бустай хийх гадаад валютын аливаа гүйлгээ, гадаад валютын дотоодын захын зохицуулалт, валютын зохицуулалтын талаархи төрийн эрх бүхий байгууллагуудын эрх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой тайлан, мэдээлэл, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах. Гадаад валютын эрх зүйн орчныг өнөөгийн нөхцөлд нийцүүлж, валютын санхүүгийн шинэ хэрэгсэл хэрэглэх		УИХ-ын 2009 оны хаврын ээлжит чуулган	Н.Оюунчимэг	Д.Баярсайхан
9	Итгэлцлийн тухай хуулийн төсөл			УИХ-ын 2009 оны хаврын ээлжит чуулган	Ажлын хэсэг Д.Дүгэржав	Д.Баярсайхан
10	Даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 27.1.5, 25.5 дахь заалтуудад нэмэлт оруулах төслийн саналыг танилцуулж, хэлэлцүүлэх		Даатгалын нөөцийн сангийн хадгалалт, зарцуулалтад хяналт тавих Хорооны бүрэн эрхийг тодорхой болгох		С.Ганболд	Б.Шаравсамб уу
11	1.Компанийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл		1.Хувьцаат компаниудын дотоод үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалт		Д.Дүгэржав Х.Бум-Эрдэнэ Ажлын хэсэг	Д.Баярсайхан

	<p>боловсруулах ажилд хорооны саналыг тусгах 2.Шаардлагатай гэж үзвэл бие даасан хуулийн төсөл боловсруулах, эсхүл, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах</p>		<p>хийх талаарх СЗХ-ны бүрэн эрхийг тодорхой болгох 2.Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр бусад улс орнуудын туршлагыг судлах, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шаардлагатай гэж үзвэл тусгайлсан хуулийн төсөл боловсруулах асуудлыг судлах</p>			
12	<p>Аудитын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хорооны саналыг тусгаж, хамтран ажиллах</p>		<p>Санхүүгийн тайлан баталгаажуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох, тогтолцооны хувьд шинэчлэл хийх санхүүгийн тайлан баталгаажуулсан дүгнэлтийнхээ төлөө аудитын компани хариуцлага хүлээдэг байх</p>		<p>Х.Бум-Эрдэнэ М.Болортуяа Ажлын хэсэг</p>	<p>Д.Баярсайхан</p>
13	<p>Хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулах ажилд оролцох</p>		<p>Аудитын компанийн хөрөнгийн үнэлгээ хийх</p>		<p>Х.Бум-Эрдэнэ М.Болортуяа Ажлын хэсэг</p>	<p>Д.Баярсайхан</p>
14	<p>Даатгагч дампуурсан нөхцөлд нөөцийн санг</p>		<p>Даатгагч дампуурсан нөхцөл дэх даатгалын</p>		<p>С.Ганболд</p>	<p>Б.Шаравсамб уу</p>

	хэрхэх талаар судалгаа гаргаж, холбогдох журамд өөрчлөлт оруулах		нөөцийн сангийн зарцуулалтын талаар судалгаа хийх, даатгалын нөөцийн санг үүсгэн байгуулахтай холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулах			
15	1.“Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль 2.“СЗХ-ны Эрх зүйн байдлын тухай” хууль 3.“Төв банкны тухай” хууль 4.“Банкны тухай” хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судалж, шийдвэрийн төсөл боловсруулах		Санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулиудад зохих нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Монгол банктай хамтран судлан боловсруулах		Д.Дүгэржав Х.Бум-Эрдэнэ Ажлын хэсэг	Д.Баярсайхан
16	Аудит, хөрөнгийн үнэлгээний мэдээллийн нэгдсэн сан байгуулах		Хорооны зохицуулалтын хүрээнд мэдээллийн сан бүрдүүлэх		М.Болортуяа Х.Бум-Эрдэнэ Ажлын хэсэг	Д.Баярсайхан

